

Mongol - Agape Судрууд - God's Love Letter Scriptures

Иохан 15:9 Эцэг Намайг яаж хайрласан шиг Би бас та нарыг хайрласан.
Миний хайр дотор байгтун.

Исаиа 43:1 Харин одоо Иаков оо, чамайг Бүтээгч ЭЗЭН ингэж айлдаж байна. Израиль аа, чамайг буй болгогч ЭЗЭН ингэж айлдаж байна. "Бүү айгтун. Учир нь Би чамайг аварсан. Би чамайг нэрээр чинь дуудсан. Чи бол Минийх.

Иеремиа 1:5 — Эхийн хэвлийд чамайг бүрэлдүүлэхээсээ өмнө би чамайг мэдсэн бөгөөд төрөхөөс чинь өмнө Би чамайг ариусгаж, чамайг үндэстнүүдэд эш үзүүлэгч болгон томилсон» гэв.

Иохан 15:16 Та нар Намайг сонгоогүй, харин Би та нарыг сонгосон. Та нарыг явж, жимс ургуулж, та нарын үр жимс үүрд байгаасай гэсэндээ Би та нарыг томилсон. Ингэснээр Миний нэрээр та нар Эцэгээс юуг ч гуйсанТэр та нарт өгөх юм.

3 Иохан 1:2 Хайрт минь, сэтгэл тань амжилттай байгаагийн адил аливаа үйлс тань амжилт олж, эрүүл энх байгаасай хэмээн би залбирч байна.

Исаиа 43:4 Чи Миний нүдэнд үнэтэй, хүндтэй бөгөөд Би чамд хайртай учраас Би чиний оронд өөр хүнийг өгч, чиний амийн оронд өөр хүмүүсийг солино.

Иеремиа 31:3 ЭЗЭН түүнд холоос үзэгдэн, "Би чамайг үүрдийн хайраар хайрласан. Тийм учраас Би чамайг хайр энэрлээр татсан билээ.

Хосеа 11:8 Ефраим аа, Би чамайг хэрхэн орхих вэ? Израиль аа, Би чамайг хэрхэн дайсанд тушаах вэ? Би чамайг хэрхэн Адма шиг болгох вэ? Би чамд хэрхэн Зебоим шиг хандах вэ? Зүрх минь Миний дотор бүрэн эргэж, Миний бүхий л энэрэл ноцсон байна.

Иохан 3:16 Бурхан ертөнцийг үнэхээр хайрласан тул цорын ганц Хүүгээ өгсөн. Ингэснээр Хүүд итгэгч хэн ч мөхөхгүй, харин мөнх амьтай болох юм.

Исаиа 49:15,16 «Эх хүн хөхүүл хүүхдээ мартаж чадах уу? Төрүүлсэн хөвгүүнээ энэрэхгүй байж чадах уу? Хэдийгээр тэр мартаж болох ч, Би чамайг мартахгүй. 16 Үзэгтүн, Би алгандаа чамайг сийлсэн. Чиний хэрмүүд үргэлж Миний өмнө байдаг.

Исаиа 41:13 Учир нь Би бол чиний баруун гараас атгадаг чиний Бурхан ЭЗЭН билээ. Би чамд «Бүү ай. Би чамд тусална» гэж айлдаж байна.

Матай 28:20 Миний та нарт тушаасан бүгдийг сахин биелүүлэхийг тэдэнд заа. Харагтун, үеийн төгсгөл хүртэл Би та нартай үргэлж хамт байх болно гэж айлдав.

Иохан 14:1 Та нар зүрхээ бүү зовоо. Бурханд итгэ, мөн Надад итгэ.

Исаиа 41:14 Бүү айгтун. Өт Иаков, Израилийн эрчүүд ээ. Би чамд тусална. Чиний Золигч бол Израилийн Ариун Нэгэн юм" гэж ЭЗЭН тунхаглаж байна.

Исаиа 43:2 Чамайг ус гатлахад Би чамтай хамт байна. Голоор туулахдаа чи живэхгүй. Гал дундуур явсан ч чи түлэгдэхгүй, дөл нь ч чамайг шатаахгүй.

Дуулал 23:1-6 Давидын дуулал. ЭЗЭН бол миний хоньчин, Надад дутах зүйл нэг ч үгүй. 2 Тэр намайг ногоон бэлчээрт хэвтүүлж, Дөлгөөн усны дэргэдүүр хөтөлдөг. 3 Тэр миний сэтгэлийг сэргээдэг. Тэр Өөрийнхөө нэрийн төлөө Зөвийн замаар намайг хөтөлдөг. 4 Үхлийн харанхуйн хөндийгөөр туулавч Би хор хөнөөлөөс айхгүй, Учир нь Та надтай хамт байна. Таны саваа, Таны таяг намайг тайвшруулдаг. 5 Та миний дайснуудын өмнө надад ширээ засдаг. Та миний толгойг тосоор тосолсон. Аяга минь дүүрч бялхдаг. 6 Сайн сайхан хийгээд хайр энэрэл Насан туршид минь намайг лавтай яа дагана. Би ЭЗЭНий өргөөнд мөнхөд оршин суух болно.

Иохан 14:27 Амар амгаланг Би та нарт үлдээнэ. Би Өөрийн амар амгалангаа та нарт өгнө. Ертөнцийн өгдгөөс өөр юмыг Би та нарт өгч байна. Та нар зүрхээ бүү зовоо. Бүү ай.

Филиппой 4:7 Бүх оюун ухаанаас дээгүүрх Бурханы амар тайван нь Христ Есүс дотор та нарын зүрх бодлыг тань хамгаална.

Сургаалт үгс 3:24 Чи хэвтэх үедээ ч айж эмээхгүй. Хэвтэх үедээ ч зүүд нойр чинь сайхан байх болно.

Дуулал 4:8 Би амар амгалан хэвтэж, унтах болно. Намайг аюулгүйгээр аж төрүүлэгч нь, ЭЗЭН, Зөвхөн Та билээ.

Дуулал 33:18 Харагтун, ЭЗЭНий мэлмий Өөрөөс нь эмээгчдийг, Түүний хайр энэрэлд найдагчдыг хардаг нь

Ром 5:2 Мөн дотор нь зогсдог энэхүү нигүүлсэл уруу бид Түүгээр дамжуулан итгэлээр орох боломжтой болсон бөгөөд бид Бурханы алдрын найдварт баярладаг.

Исаиа 55:12 "Учир нь чи баяртайгаар гарч явж, амар тайвнаар хөтлүүлнэ. Уул толгод чиний өмнө баярлан уухайлж, талын бүх модод алга ташицгаана.

Иохан 16:22 Тиймээс одоо та нар уй гашуу боловч Би та нартай дахин уулзана. Та нарын зүрх баярлана. Та нарын баяр баясгалангхэн ч та нараас булаахгүй.

Лук 12:9 Харин хүмүүсийн өмнө Намайг үгүйсгэгч хүн нь Бурханытэнгэр элч нарын өмнө үгүйсгэгдэнэ.

Матай 10:30 та нарын толгой дээрх ширхэг үсийг чинь хүртэл бүгдийг нь тоолсон байна.

Исаиа 54:10 Уулс ганхаж, толгод доргивч, Миний энэрэл хайр чамаас салахгүй, Миний энхийн гэрээ хөндөгдөхгүй" гэж чамайг энэрэгч ЭЗЭН

айлдаж байна.

Матай 11:28-30 Эцэж туйлдсан, хүнд дарамт үүрсэн хүмүүс ээ, бүгд Над уруу ир. Би та нарт амралтыг өгье. 29 Буулгыг минь өөр дээрээ авч, Надаас суралц. Учир нь Би зүрх сэтгэлдээ дөлгөөн, даруу билээ. Тэгээд Та нар сэтгэлдээ амралтыг олох болно. 30 Миний буулга амархан, Миний ачаа хөнгөн гэв.

Соломоны дуун 2:10 Миний хайрт надад хэлэх нь "Босоорой, хонгор минь, үзэсгэлэн гоо бүсгүй минь, хамтдаа явъя.

Хосеа 2:14,19,20 "Тэгэхээр харагтун, Би түүнийг уруу татан цөлд авчраад, түүнтэй эелдгээр ярих болно. 19 Би чамтай мөнхөд сүй тавина. Тийм ээ, Би зөвт байдал, шударга ёс, хайр энэрэл, өршөөлөөр чамтай сүй тавина. 20 Би чамтай итгэмжит байдал дотор сүй тавина. Тэгээд чи ЭЗЭНийг мэдэх болно.

Египетээс гарсан нь 3:14 Бурхан Мосед — Би бол "Би байдаг" гэв. Тэгээд Тэр — Израилийн хөвгүүдэд чи "«Би байдаг» намайг та нар уруу илгээв" гэж хэл гэлээ.

Хосеа 13:4 Гэвч Египет газарт байх үеэс Би та нарын Бурхан ЭЗЭН байсаар байсан. Та нар Надаас өөр ямар ч бурхныг мэдээгүй байсан. Учир нь Надаас өөр ямар ч аврагч байхгүй.

Иохан 15:14 Хэрэв та нар Миний тушаасныг хийвэл, та нар Миний нөхөд мөн.

Илчлэлт 3:20 Харагтун, Би үүдэн дээр зогсоод тогшиж байна. Хэрэв хэн нэгэн нь Миний дуут сонсоод хаалгаа нээвэл, Би түүний дотор орж, түүнтэй хамт, тэр Надтай хамт хооллоно.

Pastor T. John Franklin
Church of Salvation, Healing, and Deliverance
COS-HAD.org